



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/06.

Улаанбаатар хот

Дэн буудлын зөвшөөрөл
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.16, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 7.6, 10.1, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь заалт, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2015 оны 02/129 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороонд байрлах "Би Би Эйч Эйч" ХХК-ын "Ивээл" дэн буудлын 14/102 тоот, "Их Баян нуур" ХХК-ын "Өнөр" дэн буудлын 14/104 тоот зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тушаалыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтсүүдэд хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА



1150500018